

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН

2026.04.30

Улаанбаатар хот

Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 9:00 цагт тус Хорооны хурлын танхимд зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Хуулийн газрын дарга Т.Наранбат, Монголын Залуучуудын эвсэл холбоо ГҮТББ-ын тэргүүн Т.Амарзаяа, ажилтан А.Ариунзаяа, Тогтвортой хөгжлийн ирээдүй ТББ-ын сэтгүүлч О.Ариунбилэг, Сонгуулийн ерөнхий хорооны албан хаагч нар оролцов.



Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ хэлэлцүүлгийг нээж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулав.

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн 8 удаагийн ээлжит сонгуулийн чөлөөт, ардчилсан сонгуулийн зарчмаар зохион байгуулсан бөгөөд энэ хугацаанд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах харилцааг 4 удаагийн шинэчилсэн найруулга, түүнд оруулсан нийт 13 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулж байсан.

Монгол Улс 2012 оноос хойш сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд буюу санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэснээр уг үйл ажиллагаанд хүний субъектив хүчин зүйлээс шалтгаалах нөлөөллийг бүрэн арилгаж сонгуулийг чөлөөт, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж байна. Мөн сонгуулийн автоматжуулсан системийг сонгуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр 2013 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиас эхлэн гадаад улсад байгаа иргэд, сонгогчдийн сонгох эрхээ эдэлж, сонгуульд оролцох нөхцөл, боломжийг бүрдүүлэн ажилласан ба сонгуулийн ирц оролцоо буурч байгаа гол шалтгаан нөхцлийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос 2025 онд 21 аймаг, 330 сумын нийт 11700 сонгогчийн хамруулсан “Сонгогчийн зан төлөвийн судалгаа”-ны тайланд дурдсан үр дүнгээс үзвэл сонгуульд оролцоогүй шалтгааны 33.9 хувь нь “санал авах өдөр байнгын оршин суугаа газраасаа өөр газарт байсан”, 7.7 хувь нь оюутан, орон нутагт оршин суух хаягтай”, 0.5 хувь нь “гадаад улсад байсан” зэрэг шалтгаантай байна.

Монгол Улс сонгууль зохион байгуулах үйл ажиллагаандаа сонгуулийн автоматжуулсан системийг нэвтрүүлсэн сайн туршлагатай боловч гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг хөнгөвчилж сонгогчдод ээлтэй болгох, санал авах өдөр байнгын оршин суугаа газраасаа өөр газарт тодорхой шалтгааны улмаас зорчиж байгаа сонгогч болон санал авах өдөр санал авах байранд очиж саналаа өгөх боломжгүй сонгогчдын саналыг урьдчилан авах гэх зэрэг санал авах төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааны тухайд

Албан бус тоо баримтаар Монгол Улсаас гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа 200.000 гаруй иргэн байдаг, харин статистик тоо баримтад дурдсанаар 120000 орчим сонгогч гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа талаар мэдээлэл байна. Гадаад улсад байгаа иргэдийн сонгуулийн ирц оролцооны хувьд авч үзвэл:

2013 оны сонгуульд 6233 сонгогч бүртгүүлж 4248 сонгогч буюу 68.2 хувь

2017 оны сонгуульд 7374 сонгогч бүртгүүлж 7209 сонгогч буюу 66.8 хувь

2021 оны сонгуульд 7398 сонгогч бүртгүүлж 5568 сонгогч буюу 75.30 хувь

Гадаад улсад байгаа иргэдээс санал авсан дээрх гурван удаагийн сонгуульд гадаад улсад байгаа нийт сонгогчийн талаарх статистик тоон мэдээтэй харьцуулан үзвэл 5-6 хувь нь сонгуульд оролцохоор бүртгүүлж, ийнхүү бүртгүүлсэн сонгогчдоос дунджаар 65 хувь нь сонгуульд оролцож, сонгох эрхээ хэрэгжүүлжээ.

Гадаад улсад байгаа сонгогчдын сонгуулийн ирц оролцоо маш бага түвшин байгаа шалтгааныг зохион байгуулалт талаас нь авч үзвэл:

1-рт саналаа өгөхийн тулд хуулиар тогтоосон хугацаанд урьдчилан бүртгүүлэх,

2-рт Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй хотод байгаа сонгогч саналаа өгөхөд хүндрэл үүсдэг,

3-рт санал авах ажиллагаа нь сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө эхэлж, дуусч байгаа нь мэдээлэл, мөрийн хөтөлбөрт үндэслэн сонголтоо хийх боломжийг хязгаарладаг,

4-рт санал авах өдөр цөөн буюу 2 хүртэл өдөр байхаар тогтоодог.

Иймд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд буюу зохион байгуулах үйл ажиллагаанаас шалтгаалан ирц оролцоо бага байхад нөлөөлж буй хүчин зүйлийг зайлшгүй өөрчилж, сонгогчдод ээлтэй сонгууль зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна гэж үзсэн.

Уг асуудлаар Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ажлын хэсэг байгуулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, уулзалтыг байнга зохион байгуулж санал, дүгнэлт гаргасаар байгаа.

Сонгуулийн ирц оролцоо буурч байгаа дараагийн гол шалтгаан нь Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулсан судалгаанд дурдсанаар оршин суугаа хаягаасаа өөр газарт байгаа сонгогчийн саналыг авах, мөн санал авах өдөр өөрийн оршин суугаа газраасаа өөр газарт байх сонгогчийн саналыг урьдчилан авах арга хэлбэрийг зайлшгүй нэвтрүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Сонгуульд оролцох эрхээ эдлэх боломж нь зохион байгуулалтын болон бусад хүчин зүйлээс хамаарч хязгаарлагдмал буюу сонгох эрхээ төдийлөн бүрэн эдэлж чаддаггүй дээрх шалтгаан бүхий сонгогчдийн тоо мэдээллийг авч үзвэл:

Гадаад улсад байгаа иргэд 120000, улирлын шинж чанартай ажил, хөдөлмөр эрхэлдэг 56000 /уул, уурхай, ач тээвэр/, оюутан 20000, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд буюу буюу шатны сонгуулийн байгууллагад сонгуулийн үед ажилладаг 46000 төрийн албан хаагч буюу нийт 250000 орчим сонгогчийн сонгох эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг зайлшгүй бүрдүүлэх шаардлага үүсээд байна.

Уг асуудлаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоол гарч “хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гадаад улсад байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаягнаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, санал өгөх боломжит хувилбарыг тодорхойлж, эрх зүйн орчныг бий болгох талаар санал боловсруулах”-ыг үүрэг болгосон болно.

Хуулийг төслийг дээр дурдсан үндэслэн, шалтгаан, Улсын Их Хурлын тогтоолд үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгав. Үүнд:

1. Гадаад улсад байгаа иргэд санал өгөхдөө урьдчилан бүртгүүлэхгүй бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал өгөх боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

2. Санал авах өдөр саналаа өгөх боломжгүй сонгогчийн саналыг урьдчилан авах төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

3. Санал авах өдөр тухайн сонгогчийн харьяа хэсгийн хороо хамаарах аймаг, нийслэлээс өөр нутаг дэвсгэрт байгаа сонгогчийн саналыг авах, түүнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Мөн хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээнээс шалтгаалан дагалдан гарах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай. Тухайлбал санал авах төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхдээ сонгуулийн автоматжуулсан систем, түүнд хамаарах тоног төхөөрөмжийн судлах, тодорхойлох, баталгаажуулах зэрэг чиг үүргийг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн чиг үүрэгт нэмэлтээр тусгах зорилгоор Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдан гарах хуулийн төслийг боловсруулсан байна.

Гадаадад байгаа иргэдээс санал авах ажиллагаа

Гадаад байгаа иргэд саналаа өгөхдөө 2 удаа дипломат төлөөлөгчдийн газар очдог байсан нь их хүндрэл үүсгэж байгаа. Одоо энэ хуулийн төслөөр гадаадад байгаа иргэн урьдчилж бүртгүүлэхгүй шууд очиж саналаа өгөх зохицуулалт үүсэж байгаа юм. Мөн санал авах өдөр 4 хоног байсан бол энэ хуулийн төслөөр 5 хоног болгосон.

Дипломат төлөөлөгчийн газар дээр санал тоолох төхөөрөмжөөр сонгогчдын саналыг авна. Хуулиар гадаадад байгаа иргэдээс саналыг нь аваад саналын хуудсаа Хорооны дугуй зааланд тоолдог байсан. Харин хуульд өөрчлөлт орсноор Дипломат төлөөлөгчийн газар сонгогчдын саналыг аваад санал тоолох төхөөрөмжөөс мэдээллийг дамжуулдаг болбол санхүүгийн хувьд ч гэсэн хэмнэлт үүсэхээр байгаа.

Урьдчилсан санал авах ажиллагаа:

Урьдчилсан санал авах ажиллагааг хуулийн төсөлд тусгаснаар уул, уурхайн салбар, оюутан, төрийн албан хаагч болон бусад шалтгаан үүссэн тохиолдолд урьдчилсан саналаа өгөх нөхцөл үүснэ. Нэг цэгийн үйлчилгээг түшиглэн санал тоолох төхөөрөмжөө суурилуулан урьдчилсан саналаа авах боломжтой гэж үзэж байгаа. Сонгогч нэг цэгийн үйлчилгээнд байршуулсан санал тоолох төхөөрөмжид саналаа өгөхөд өөрийн оршин суугаа нутаг захиргааныхан саналын хуудас гарч ирэх зохицуулалттай юм. Сонгогч аль ч нэг цэгийн үйлчилгээнд очиж саналаа өгөх нөхцөл үүснэ.

САНАЛ ХҮСЭЛТ:

Тогтвортой хөгжлийн ирээдүй ТББ-ын сэтгүүлч О.Ариунбилэг:



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гэж нэрэлмээргүй байна. Иргэдэд ойлгомжтой байх хүрээнд сонгуулийн зохион байгуулалтад өөрчлөлт оруулж байгаа гэдгээр мэдээллийг түгээх хэрэгтэй. Сонгогч саналаа өгчихөөд дахин санал өгөх боломжгүй блоклогдоод мэдээлэл серверт шууд очих шаардлагатай байгаа юм.

Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ: Бүх хүний дата мэдээлэл нэг хэсэг дээр бүгд очдоггүй. Харин тэнд бүртгэлтэй оршин суудаг иргэдийн мэдээлэл л хэсэг дээр очно. Нэг үйлчилгээн дээр санал тоолох төхөөрөмж байрлуулахад тэр цэг дээр бүх хүний дата очно гэсэн үг. Энэ нь аюулгүй байдал талаасаа юм.

Монголын Залуучуудын эвсэл холбоо ГҮТББ-ын тэргүүн Т.Амарзаяа:

Сонгогчдын саналыг авах төрөл их олон байдаг. Эстони улс гэхэд л 13 төрлөөр сонгогчдын саналыг авч байгаа. Тэгэхээр манай улс сонгогчдын саналыг авах төрлөө нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжиж байгаа. Интернэт орчинд хөгжиж байгаа болохоор өөр өөр олон төрлийг хуулиндаа нэвтрүүлээд явах нь зөв гэж харж байгаа.

Хуулийн төслөөр сонгуулийн зохион байгуулалт өөрчлөгдөх юм байна. Дипломат төлөөлөгчийн газаргүй нутагт сонгуулийн хэсэг байгуулна. Сонгогчдоос

санал авах өдөр 5 хоног болохоор харагдаж байна. Тэгэхээр манай иргэний нийгийн байгууллагын ажиглалт ачаалал үүсэж, хүний нөөцийн асуудал гарч ирж болзошгүй үүндээр анхаарах хэрэгтэй.

Тогтвортой хөгжлийн ирээдүй ТББ-ын сэтгүүлч О.Ариунбилэг:

Таван хоногийн хугацаанд тог тасархад мэдээлэл тасрах явдал гарах уу?

Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ: Байхгүй. Санал тоолох төхөөрөмж өөр дээрээ тог баригчтай. Тог баригч 24 цаг тасралтгүй ажиллана. Мөн санал тоолох төхөөрөмжийн доор саналын хуудас нь байгаа тэрийг тоолж болно.

Монголын Залуучуудын эвсэл холбоо ГҮТББ-ын тэргүүн Т.Амарзаяа:

Иргэний ниймийн байгууллага дээр ачаалал үүсэх юм байна. Ажиглагч нараа яаж хуваарилах уу гэхээс авахуулаад. Бас нэг анхаарах асуудал нь мөнгө тараах үйл ажиллагаа олон хоног болох юм байна. Үүн дээр анхаарах хэрэгтэй. Олон эрсдэл харагдаж байна. Хуулийн төсөл батлагдвал Ерөнхийлөгчийн сонгууль дээр хэрэгжүүлээд Улсын Их Хурлын сонгуульд туршлагтай болох юм байна. Хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байна. Аль болох сонгох эрхийг нь эдлүүлэх хэрэгтэй. Энэ хуулийн төсөл хэрэгжсэнээр цараа алга болох юм байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал:

Энэ хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаа. Мөн 50 вүүт дээр хэдэн сонгогч саналаа өгнө гэсэн судалгаа байна уу?

Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ: Тэр бол боломжгүй, яг хэд ирэх нь тодорхойгүй байгаа. Нэг цэгийн үйлчилгээн дээр байрлуулсан санал тоолох төхөөрөмжид 2 сая сонгогчийн мэдээлэл байгаа тэгэхээр хэд ирэх нь тодорхойгүй. Ойролцоогоор 130 орчим мянган хүний хэрэгцээ байгаа. 1 вүүтийн тооцоолол байгаа. Нийт 50 орчим вүүт ажиллана гэсэн ойролцоо тооцоо гарсан.

Монголын Залуучуудын эвсэл холбоо ГҮТББ-ын тэргүүн Т.Амарзаяа:

Хуулийн төслийг хэрэгжүүлээд үзэх нь зөв гэж үзэж байна. Сонгуулийн зардал хэр гарч байна?

Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ: Нэг хэсэг дээр 12 сая гаруй төгрөгийн зардлын тооцоолол гарсан. Гадаадад сонгуулийн хэсэг байгуулахад. Бас нэг зүйл байгаа. Бид бүхэн сонгуулийн сайн дурын ажилтанг идэвхжүүлэх хэрэгтэй байгаа. Тэгэснээрээ залуучуудын сонгуульд оролцох идэвхийг нэмэгдүүлж бид нар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй. Хамтран ажилласан та бүхэнд баярлалаа.

Хууль санаачлагч нар



УИХ-ын гишүүн
Дуламын БУМ-ОЧИР



УИХ-ын гишүүн
Чинбаатарын АНАР



УИХ-ын гишүүн
Жудагийн БАЯРМАА



УИХ-ын гишүүн
Жаргалсайханы ЗОЛЖАРГ...

Боловсруулж буй

Өргөн баригдсан

Хэлэлцэх эсэх

Ажлын хэсэг

Анхны хэлэлцүүлэг

Эцсийн хэлэлцүүлэг

Батлах

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 ОНЫ 3-Р САРЫН 12 ӨДӨР

УЛААНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



✓ Дагах



1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:



1/ 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт:



“3.1.14. “Дипломат төлөөлөгчийн газар” гэж Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг.”



2/ 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг:



“Төв комисс нь сонгогчийн тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газарт энэ хуульд нийцүүлэн салбар комисс байгуулж болно.”



3/ 57¹ дугаар зүйл. Урьдчилан санал авах ажиллагаа



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ**

№	Ирүүлсэн санал, огноо	Албан бичгийн дугаар	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл, 2025.06.20	5/195	Гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн санал авах өдөр санал өгсөн сонгогчоор гарын үсэг зуруулж буй үйл ажиллагааг цахим хэлбэрт эрсдэлгүй шилжүүлэх, тухайн иргэн өөрийн өгсөн саналаа хянах боломж, нөхцөлөөр хангах, кибер аюулгүй байдлыг бүрэн хангах.	<i>Туйм</i>
2.	Гадаад харилцааны яам, 2025.06.24	01/1217	Хилийн чанадад оршин суугаа монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол нэгдсэн системийг ашиглан цахимаар сонгуульд оролцох эрхийг хангахыг дэмжиж байна. Сонгуулийг цахим хэлбэрээр явуулахдаа иргэдийн танин баталгаажуулалт, мэдээлэл дамжуулалт болон сүлжээний аюулгүй байдлыг сайтар хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэх.	<i>Туйм</i>
3.	И-Монгол академи, 2025.06.20	01/287	Бүх шатны сонгуульд хилийн чанадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн саналыг цахимаар авах системийн талаар судалгаа болон холбогдон гарах зардлын тооцоо ирүүлсэн.	<i>Туйм</i>
4.	Улсын бүртгэлийн ерөнхий газар, 2025.06.19	01/8143	Тоон гарын үсгийн олголтыг эрчимжүүлэх, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийг ашиглан сонгогчийг таньж баталгаажуулахдаа царай таних системийг хэрэглээнд нэвтрүүлэх.	<i>Туйм</i>
5.	Үндэсний дата төв, 2025.06.20	01/215	Клауд тоон гарын үсгийн олголтыг эрчимжүүлж тус системээр баталгаажуулж нэвтрүүлэх замаар хилийн чанад дах Монгол Улсын иргэд	<i>Туйм</i>

			и-монгол төрийн цахим үйлчилгээний системийг ашиглах, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах.	
6.	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, 2025.06.20	01/65	Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид хилийн чанад дахь Монгол иргэдийг цахим сонгуульд оролцуулахтай холбоотой зохицуулалт байхгүй тул шаардлагатай нэмэлт өөрчлөлт тусгах.	<i>Туйм</i>
7.	Үндэсний статистикийн хороо, 2025.06.30	01/565	Хил хамгаалах ерөнхий газар болон Гадаад харилцааны яамны мэдээлэлд тулгуурлан гадаад Улсад оршин суугаа иргэдийн мэдээллийн санг үүсгэх.	<i>Туйм</i>
8.	Хүний эрхийн үндэсний комисс	01/1183	Сонгуулийн тогтолцоо, сонгуулийн түвшнээс үл хамааран гадаад улсад байгаа иргэдийн саналаа өгөх эрхийг хангасан зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах, гадаад улсад байгаа бүх иргэдийг саналаа өгөх боломжоор хангах.	<i>Туйм</i>

И МОНГОЛ АКАДЕМИ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Мэдээлэл, технологийн үндэсний парк,
Бага тойруу 49, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 7711 1197, Факс: (976) 7711 1197,
Цахим шуудан: info@ema.gov.mn,
Цахим хуудас: www.ema.gov.mn

2025.06.20 № 01/287
танай _____-ны № _____-т

УИХ-ЫН ГИШҮҮН Д.БУМ-ОЧИР
ТАНАА

Таны хүсэлтийн дагуу цахим сонгууль болон иргэнийг танин баталгаажуулах шийдэл, түүнтэй холбогдон гарах зардлын тооцоотой холбоотой саналыг хавсралтаар хүргүүлж байна. Хүлээн авна уу.

ЗАХИРАЛ  Б.МЯГМАРНАРАН



И Монгол академи УТҮГ-ын 2025 оны
 06 дугаар сарын 20 -ны өдрийн
 тоот албан бичгийн хавсралт



№	Албан тушаал	Тоо	Нэгж тогтмол зардал	Хугацаа - Сар	Нийт зардал/Төгрөг
1	Хяналтын менежер	2	2,500,000	24	120,000,000
2	Онлайн оператор	8	2,500,000	24	480,000,000
3	Түрээсийн интернэт зардал	1	5,000,000	24	120,000,000
4	Оффис түрээс	1	4,000,000	24	96,000,000
Нийт зардал:					816,000,000

№	Худалдан авалт	Тоо	Нэгж үнэ	Нийт зардал	Тайлбар
1	Компьютер	10	3000000	30,000,000	Энгийн desktop
2	Зоом эрх	2	800000	1,600,000	Нэг удаа эрхээ аваад дундаа ашиглах гэж тооцов.
3	Принтер	1	2000000	2,000,000	Баг дундаа ашиглана.
4	Ширээ	8	850,000	6,800,000	Бүх оператор тус бүрдээ сууна.
5	Сандал	8	300000	2,400,000	Бүх оператор тус бүрдээ сууна.
6	Өндөр нягтаршилтай камер	8	800,000	6,400,000	Бүх оператор тус бүрдээ ашиглах өндөр нягтаршилтай камер
7	Операторын чихэвч	8	1,065,000	8,520,000	Бүх оператор тус бүрдээ ашиглах чихэвч
8	Сүлжээ тохируулах, гүйцэтгэх ажил	1	2,000,000	2,000,000	Оффисийн компьютер сүлжээний холболт хийх зардал
Нийт зардал:				59,720,096	

Нэг удаагийн худалдан авалт	59,720,096
Урсгал зардал	0
Нийт төсөв:	875,720,096

БҮХ ШАТНЫ СОНГУУЛЬД ХИЛИЙН ЧАНАДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН САНАЛЫГ ЦАХИМААР АВАХ СИСТЕМИЙН ТАЛААР

2025 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын иргэн дэлхийн аль ч оронд амьдарч байсан үндсэн хуулийн дагуу төрөө байгуулахад оролцох эрхтэй. Энэхүү эрхийг хэрэгжүүлэхийн тулд гадаадад байгаа иргэдэд төрийн сонгуульд зайнаас оролцох боломжийг нээх шаардлага урган гарч байгаа билээ. Өнөөгийн байдлаар дэлхийн 50 гаруй улсын иргэд шуудангаар санал өгч болдог бол 18 улсад цахимаар сонгуульд оролцох боломжийг бүрдүүлсэн байна.

1. ФИЛИППИН УЛСЫН ГАДААДАД БАЙГАА ИРГЭДЭЭСЭЭ САНАЛ АВАХ ЦАХИМ СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААЛТЫН ТУРШЛАГА

1.1. Ерөнхий мэдээлэл:

Филиппин улс нь нийт 115 сая хүн амтайгаас 68 сая нь сонгуулийн насны хүн ам юм. Хилийн чанадад тус улсын 12 сая иргэн амьдардгаас 1.2 сая иргэн парламентын сонгуульд санал өгөхөөр урьдчилж бүртгүүлсэн бол тэдний 11% нь буюу 134,000 иргэн саналаа онлайн аргаар өгсөн. Энэ нь хангалтгүй дүн гэж үзэж болох ба урьдчилан очиж бүртгүүлдэг процессоос болж харьцангуй цөөн тооны иргэд санал өгөхөөр бүртгүүлсэн гэж үзэж байна. Энэ удаагийн буюу 2025 оны парламентын сонгуулиар гадаадад амьдарч буй Филиппин улсын иргэд анх удаа интернэтээр санал өгөх боломжтой болсон. Филиппиний сонгуулийн хорооноос 2023 онд гадаадад байгаа иргэдийн саналыг цахимаар авах тухай шийдвэрийг зарласан нь иргэдийнхээ сэтгэл зүйг бэлдсэн чухал алхам болсон байна. Зарласнаас хойших 2 жилийн хугацаанд эрхзүйн орчныг бий болгох Overseas voting act хуулийг баталж, цахим санал хураалтын шийдлээ боловсруулах, ажлын даалгаврыг бэлтгэх, тендер зарлах, худалдан авалт хийх, хилийн чанадад байгаа иргэддээ мэдээлэл өгөх, гадаадад суугаа элчин сайдын яамд, консулын газруудаа мэдээллээр хангах зэрэг бэлтгэл ажлыг сайтар базаасан байна. Сонгуулийн санал авах үйл ажиллагаа ерөнхийдөө амжилттай явагдсан ч хэд хэдэн сөрөг асуудал гарсныг энд дурдах нь зүйтэй. Жишээлбэл санал авах явцад гадаадад байгаа иргэдэд систем ашиглах заавар, мэдээлэл дутмаг хүрсэн, мөн санал өгөх явцад юу нь мэдэгдэхгүй QR код гарч ирснээр иргэдэд ойлгомжгүй байдал бий болгосон зэрэг алдаа дутагдлууд гарсан байна. Тус улс өөрийн улс доторх иргэдийн саналыг авахдаа бөглөсөн саналын хуудсыг хар машинд хийж уншуулсны дараа “энэ таны бөглөсөн сонголтууд мөн үү” гэсэн утгатай баталгаажуулах цаасыг санал өгөгчид харуулдаг бөгөөд тухайн цаасан дээр хэвлэгдсэн нэрс тухайн хүний дугуйлсан нэртэй яв цав тохирч байгааг баталгаажуулах зорилготой юм. Гэтэл уг шийдлийг гадаадад байгаа сонгогчдын цахим санал хураалтын системд нэвтрүүлэх гэж зорьсноос дээрх итгэлцэл, бухимдлын асуудал үүссэн байна. Зарим иргэдийн хувьд өөрийн өгсөн санал нь гээгдсэн, өөр нэр дэвшигчид өгөгдсөн, анхнаасаа тохируулсан байсан зэрэг хардлага гарсан ба цаашид дээрх хэлбэрээр иргэдийн саналыг цахимаар авах тохиолдолд хөндлөнгийн хяналтын механизм оруулж ирэх, эсвэл таны санал

өөрчлөгдөөгүй шүү гэдгийг батлан харуулах шийдэл хэрэгтэй нь дээрх жишээнээс харагдаж байна.

1.2. Цахим шийдэл:

Сонгуулийн санал авах үйл ажиллагааг Online Voting and Counting System (OVCS) буюу Цахим санал хураалт ба тооллогын систем-ээр дамжуулан хэрэгжүүлжээ. Ингэхдээ цахим санал хураалтын шийдэл болон системийг Филиппин улсын SMS Global Technologies, Inc. болон АНУ-д төвтэй Sequent Tech, Inc. гэсэн хоёр компанийн түншлэл боловсруулсан. Sequent Tech, Inc. олон улсын компани нь харьцангуй бага үнийн санал (2 сая доллар) өгч тендерт шалгарсан ба олон улсад том жижиг 200 гаруй сонгуульд цахим шийдэл дээр хамтран ажилласан, туршлагатай компани байна. Системийн хувьд open source, 2011 оноос эхлэн академик судалгаанд үндэслэн, эрдэмтэн судлаачдын зөвлөх багийн зөвлөмж дор хөгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд 10 орны 4 сая орчим сонгогчийн саналыг онлайн аргаар авах ажилд оролцсон байна.

SMS Global Technologies, Inc.: Филиппинд байрладаг, мэдээллийн технологи болон харилцаа холбооны шийдлээр мэргэшсэн компани бөгөөд өмнө нь тус улсын Үндэсний Статистикийн Газрын "National ID" төслийн аюулгүй онлайн үйлчилгээний үүлэн системийг хөгжүүлж байсан туршлагатай.

Sequent Tech, Inc.: АНУ-д төвтэй технологийн компани бөгөөд аюулгүй байдлын өндөр түвшний шаардлагыг хангасан сонгуулийн санал хураалтын системүүдийг хөгжүүлдэг. Тэдний хамтран боловсруулсан цахим санал хураалтын систем нь санал өгөхөөс эхлээд тоолох хүртэлх бүх үйл явцыг баталгаажуулах, нууцлалыг хангах, шалгах боломжтой бөгөөд хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах зорилгоор нүүр царай таних зэрэг биометрик баталгаажуулалтыг ашигладаг.

1.3. Сонгуулийн цахим шийдлээр тэргүүлэгч компаниудыг харьцуулсан байдал:

Дэлхий дээр сонгуулийн санал хураалтын цахим шийдэл (e-voting solutions) санал болгодог шилдэг 5 компанийг доор харуулав. Эдгээр компаниудыг сонгохдоо тэдний технологийн найдвартай байдал, хэрэглээний цар хүрээ, салбарын нэр хүнд, хэрэглэгчдийн сэтгэгдэл зэргийг харгалзан үзэж шилдэг гэх тодотголыг өгдөг. Үүнд:

1. Smartmatic

- 2000 онд АНУ-д үүсгэн байгуулагдсан Smartmatic нь цахим сонгуулийн технологийн шийдэл, логистик, үйлчилгээгээрээ танигдсан. Тус компани нь Эстонид интернэт санал хураалтын төв байгуулсан бөгөөд Филиппин зэрэг улсад цахим сонгуулийн систем буюу бидний мэддэгээр хар машиныг амжилттай нэвтрүүлсэн. Smartmatic-ийн шийдэл нь аюулгүй байдал, ил тод байдлыг хангахад чиглэсэн блокчэйн технологи, voter-verified paper audit trails (VVPAT) зэргийг ашигладаг.
- **Эх сурвалж:** Smartmatic-ийн вэбсайт (www.smartmatic.com), Forbes-ийн нийтлэл (2017-12-03), Appvizer-ийн тойм (2025).

2. Election Systems & Software (ES&S)

- 1979 онд АНУ-ын Небраска мужид байгуулагдсан ES&S нь дэлхийн хамгийн том сонгуулийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн нэг юм. Тус компани нь vote tabulators, DRE voting machines, ballot-marking devices, электрон саналын дэвтэр зэрэг шийдлүүдийг санал болгодог бөгөөд АНУ-ын 4500 гаруй дүүрэгт үйлчилдэг. Гэсэн хэдий ч ES&S-ийн үйл ажиллагаа нь ил тод бус байдал, засгийн газрын албан тушаалтнуудтай ойр харилцаатай гэсэн шүүмжлэлд өртдөг.
- **Эх сурвалж:** ES&S-ийн вэбсайт (www.essvote.com), Wikipedia (2020-11-15), ProPublica-ийн нийтлэл (2019-10-29).

3. Scytl

- 2001 онд Испанид үүсгэн байгуулагдсан Scytl нь онлайн санал хураалт, сонгуулийн менежментийн шийдлээрээ танигдсан компани юм. 2016 онд АНУ-ын 980 гаруй дүүрэгт тус компанийн технологи хэрэглэгдсэн бөгөөд voter registration, poll worker management зэрэг үйлчилгээг санал болгодог. Scytl нь аюулгүй байдал, ил тод байдлыг хангахын тулд end-to-end encryption, voter anonymity зэрэг технологи ашигладаг.
- **Эх сурвалж:** Forbes-ийн нийтлэл (2017-12-03), Appvizer-ийн тойм (2025), Scytl-ийн вэбсайт (scytl.com).

4. eBallot

- eBallot нь аюулгүй онлайн санал хураалтын платформ бөгөөд корпорацууд, их сургууль, бизнесийн байгууллагуудын сонгуульд өргөн хэрэглэгддэг. Тус платформ нь хэрэглэгчдэд ээлтэй интерфэйс, voter authentication, real-time results зэрэг боломжуудыг санал болгодог бөгөөд 20 гаруй жилийн туршлагатай. eBallot-ийн үйлчлүүлэгчид тус платформын хялбар байдал, найдвартай байдлыг онцолдог.
- **Эх сурвалж:** eBallot-ийн вэбсайт (www.eballot.com), Appvizer-ийн тойм (2025), Captterra-ийн тойм (2025).

5. Simply Voting


- **Тайлбар:** 2003 онд Канадын Монреал хотод байгуулагдсан Simply Voting нь цахим сонгуулийн бүрэн үйлчилгээний шийдэл санал болгодог. Тус платформ нь интернэт, утасны, SMS санал хураалтыг санал болгодог бөгөөд аюулгүй байдлыг хангахын тулд tamper-proof electronic ballots, voter authentication зэрэг технологи ашигладаг. Simply Voting нь гольфийн клуб, багш нарын холбоо, хотын захиргааны сонгуульд хэрэглэгддэг.
- **Эх сурвалж:** Simply Voting-ийн вэбсайт (www.simplyvoting.com), Captterra-ийн тойм (2025).

Эдгээр компаниудыг сонгохдоо тэдний технологийн аюулгүй байдал, хэрэглэгчдийн сэтгэгдэл, салбарын нэр хүндийг харгалзаж үзэх боловч зарим шүүмжлэл, эрсдэлийг дагуулах магадлалтай. Жишээ нь, ES&S, Smartmatic зэрэг томоохон компаниуд ил тод байдал, Америкийн засгийн газартай хэт ойр харилцаатай гэж шүүмжлэгддэг бөгөөд энэ нь

Монгол улсын нөхцөлд итгэлцлийн асуудал үүсгэж болзошгүй. Мөн цахим сонгуулийн системийн аюулгүй байдал (кибер халдлага, техникийн алдаа) нь дэлхий даяар маргаантай хэвээр байгаа тул Монголд хэрэгжүүлэхдээ нэмэлт хяналт, туршилт хийх зайлшгүй шаардлагатай. Филиппиний санал хураалтын цахим системийн тендерт 5 дахин бага үнийн санал өгч шалгарсан Sequent Tech, Inc компанийн хувьд төдийлөн танигдаагүй ч одоогоор нэр хүндийн хувьд аливаа асуудалтай холбогдоогүй, хялбар шийдэл санал болгодоогоор ялгарсан байна.

1.4. Филиппиний сонгуулийн цахимаар санал авах ажиллагааны үе шатууд:

2. **Бүртгэл:** Филиппиний гадаадад байгаа иргэд сүүлийн 2 жилийн дотор хүссэн үедээ элчин сайдын яам болон консулын газартаа очиж сонгогчийн бүртгэл хийлгэнэ. Ингэхдээ нууц үг хүлээн авах утасны дугаар юм уу имэйл хаягаа тэмдэглүүлнэ.
3. **Хүсэлт:** Санал өгөхийн тулд гадаадад байгаа бүртгэлтэй сонгогчид 2025 оны 3-р сарын 20-ноос эхлэн <https://info-ov.comelec.gov.ph> хаягаар орж интернэтээр санал өгөх хүсэлтээ үүсгэнэ. Бүртгэл нь зөвхөн гадаадад байгаа иргэдэд зориулагдсан бөгөөд интернэт санал өгөх эрх авахын тулд энэ хаягаар орж өөрийн мэдээллийг баталгаажуулна. Баталгаажуулахдаа гэрчлэх бичиг баримт, гадаад паспортаа барин selfie хийж хавсаргана.
4. **Баталгаажуулалт:** Сонгуулийн хорооноос иргэний хүсэлтийг баталгаажуулсны дараа тухайн иргэний имэйл рүү нэвтрэх нэр, түр нууц үг илгээнэ.
5. **Нэвтрэлт:** Санал хураалт 2025 оны 4-р сарын 13-наас 5-р сарын 12-ныг хүртэл үргэлжилнэ. Иргэн энэ хугацаанд <https://onlinevoting.comelec.gov.ph> гэсэн албан ёсны санал хураалтын системд нэвтэрч саналаа өгнө. Санал өгөх эрхтэй хэрэглэгч системд нууц үг, хэрэглэгчийн нэр, нэг удаагийн код (OTP) болон биометр (нүүр царай таних) зэргээр баталгаажна.




6. Санал өгөх:

Системд нэвтэрч санал өгөх алхмууд:


1. Өөрийн хэрэглэгчийн нэр, нууц үгээр нэвтэрнэ
2. Хувийн мэдээллээ баталгаажуулна
3. Сонгогчийн хуудсыг шалгаад сонголтоо хийнэ
4. Саналаа баталгаажуулж илгээнэ

7. **Шалгах:** Санал өгсний дараа сонгогч QR код авдаг бөгөөд энэ кодыг ашиглан саналаа баталгаажуулж болно. Гэхдээ энэ тал дээр зарим иргэдэд ойлгомжгүй байсан тул шүүмжлэл дагуулсан.
8. **Нууцлал:** Нууцлалын хувьд мэдээллийг гуравдагч этгээдэд таниулахгүй байх үүднээс криптограф аргыг ашигласан байна. **Криптограф** гэдэг нь мэдээллийг нууцлах, шифрлэх, баталгаажуулах технологи бөгөөд гуравдагч этгээдээс мэдээллийг хамгаалах зорилготой математикийн болон компьютерын шинжлэх ухааны салбар юм. Тус аргыг ашигласнаар мэдээллийг итгэмжлэлтэй, өөрчлөгдөөгүй гэж батлах боломж олгоно. Өөрөөр хэлбэл миний өгсөн санал тусгай кодоор шифрлэгдэн серверт очиж, нөгөө талд зөвхөн түлхүүр үгээр тайлах боломжтой болно. Ингэснээр миний саналыг дундаас нь хэн ч өөрчилж чадахгүй.

How Asymmetric Encryption Works



1.5. Архитектур шийдэл



Хэд хэдэн давхар баталгаажуулалт ашигласан, шифрлэлт ашигласан зэрэг зөв шийдлүүдийг нэвтрүүлсэн бөгөөд санал авах, тоолох, бүртгэх серверүүд тусдаа байрласан (logical separation) байна.

- Vote Casting Server (VCS)
- Voter Authentication Server (VAS)
- Vote Counting Server (VCoS)

Санал авах хугацаанд кибер аюулгүй байдлыг мэргэжлийн байгууллагууд дээд зэргээр анхаарч, хяналтдаа байлгаж ажилласан.

2. ШВЕЙЦАР УЛСЫН САЙН ТУРШЛАГА

2025 оны байдлаар Швейцар улс нь 4 мужийн тодорхой бүлгийн иргэдээс цахим байдлаар сонгуулийн санал авч байна. (Мужууд: Basel-Stadt, St. Gallen, Thurgau, Graubünden) St. Gallen мужийн гадаадад оршин суугаа иргэд онлайнаар санал өгдөг бол Basel-Stadt муж зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ цахимаар саналыг өгөхийг зөвшөөрдөг.

Өмнө нь хийгдсэн системд 2019 онд аудит хийж, аюулгүй байдал, нууцлал хамгаалалтын ноцтой сул талууд илэрсэн учраас зогсоож байсан. Харин шинэчлэгдсэн систем нь "Бүрэн баталгаажуулах боломж"-той болсныг онцолж байгаа бөгөөд энэ нь сонгогчид болон сонгуулийн оролцогчид санал хураалтын үйл явцын халдашгүй байдлыг шалгах боломжтой болгосон хэрэг юм.

Swiss Post : Буюу Швейцарын үндэсний шуудан уг системийг хөгжүүлж, туршиж байгаа. Хамгийн сонирхолтой нь хөгжүүлсэн системийн эх кодоо нээлттэй байршуулж, сая сая хөгжүүлэгч, аюулгүй байдлын шинжээчдийн хараа хяналт доор ажиллаж байгаа юм. Мөн хуучин 2019 онд архивлагдсан цахим сонгуулийн системийн эх кодыг ч харах боломжтой. (<https://gitlab.com/swisspost-evoting>)

2.1. Цахимаар санал авах дараалал

1. Урьдчилан бүртгүүлэх

Сонгогч нь урьдчилан бүртгүүлсэн байх шаардлагатай. Зөвхөн цахимаар санал өгөх боломжтой мужийн оршин суугч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гадаадад оршин суугаа иргэн байх. Ингэхдээ мужийн эсвэл ерөнхий засаг захиргаанд бүртгүүлнэ.

2. Санал хураалтын нууц код бүхий картыг хүлээж авах.

Сонгуулийн хорооны бүртгэлийг баталгаажуулсны дараа таны гэрийн хаягаар эсвэл цахим шуудангаар нууц код агуулсан дугтуйтай картыг илгээнэ. Шуудангаар бол зөвхөн өөрт нь хүлээлгэж өгнө, цахим шуудангаар бол иргэний урьдчилан бүртгүүлсэн хувийн имэйлд очно.

3. Санал хураалтын порталд нэвтрэх

Портал : <https://www.evoting-info.ch/> (энэ бол албан ёсны санал хураалтын систем)

Систем нь 1 иргэн 2 удаа нэвтрэх боломжгүйгээр хийгдсэн.

Системд нэвтэрч санал өгөх алхмууд:

1. Иргэн нэвтрэх
2. Эхлүүлэх код оруулах (карт дээрх)
3. Сонгогчийн хуудсыг шалгаад сонголтоо хийх
4. Шифрлэх.
5. Баталгаажуулах код оруулах (карт дээрх)

6. Дэлгэц дээр гарч ирсэн эцэслэх кодыг тулгах (карт дээрх)

2.2. Цахим санал хураалтын аюулгүй байдлын шийдлүүд:

1. End to End encryption

Иргэний сонголт, веб хөтчөөс илгээгдэхээс өмнө шифрлэгдэнэ. Тийм учраас дамжуулж байгаа мэдээллийг Swiss Post, Засаг захиргаа эсвэл гуравдагч этгээд харах, тагнах боломжгүй. Public key encryption ашигласан учраас дараа саналыг тоолох үед тайлж унших боломжтой.

2. Individual Verifiability (Return Code)

Санал өгсний дараа return code харуулдаг. Энэ нь шуудангаар ирсэн саналын карт дээрх код-той таарч байвал санал амжилттай бүртгэгдсэн байна гэсэн үг. Энэ кодыг cryptographic ашиглаж үүсгэнэ.

3. Universal verifiability

Өгсөн саналыг бүгд бүртгэгдсэн эсэх, зөв тоологдсон эсэх, саналыг өөрчлөөгүй, илүү бүртгэл хийгээгүй, санал устгаагүй гэдгийг шалгах боломжийг олгоно. Иргэдийн системд итгэх итгэлийг бататгах, үйл ажиллагааны ил тод явцыг баталж харуулж байгаа аргачлал юм.

Шалгаж байгаа этгээд нь zero-knowledge proof ашиглаж шалгана.

4. Mix-net (Anonymization)

Саналууд нь cryptography-ийн процесс болох mixnet-ээр дамждаг. Энэ нь бүх оролцогчдыг танигдахгүй болгоно. Санал өгч буй иргэний саналыг нууц болгож, буцаагаад энэ иргэн ийм сонголт хийсэн гэдгийг хөөж харах боломжгүй болох юм. Шифрлэгдсэн санал нь холигдож, дахин дахин шифрлэгдэж, эцэст нь тоолох үед шифрийг тайлснаар санал өгч буй иргэн болон саналын сонголт хооронд холбоос баригдахгүй болно.

5. Нээлттэй эхийн код ба ил тод байдал.

Бүх кодоо нээлттэй болгож олон нийтэд харуулснаар хөндлөнгийн аудит, мэдээллийн аюулгүй байдлын олон фирм мэргэжилтнүүд судалж, сул тал олохоор ажилласан байна. Сул тал олж мэдэгдсэн тохиолдолд 250,000 Швейцар франк ба түүнээс дээш урамшуулал зарласан байдаг.

6. Cryptographic Proofs (Zero-knowledge proofs)

Санал хураалтын мэдээллийг задруулахгүйгээр тоолох боломжийг олгож байгаа математик тооцоолол юм. Өөрөөр хэлбэл өгсөн саналын сонголтыг харуулахгүйгээр, саналыг карт, нийлбэр тоо, болон статистик мэдээллийг шалгах боломжийг олгоно.

3. НОРВЕГИ УЛСЫН МУУ ТУРШЛАГА

2011 ба 2013 онд Норвеги улсын орон нутгийн болон парламентын сонгуульд цахим санал хураалтыг туршилтаар хэрэгжүүлсэн. Системийг Norge.no болон төрийн мэдээллийн технологийн агентлаг хамтран хөгжүүлсэн байна. Туршилт нь гадаадад байгаа норвегичүүд болон зарим дотоодын тойргуудад хязгаарлагдсан байсан.

Норвегийн Засгийн газар 2014 онд цахим санал хураалтыг цаашид үргэлжлүүлэхгүй гэж мэдэгдсэн. Гол шалтгаанууд:

- Системийг бүрэн хакердаж чадаагүй ч болзошгүй эрсдэл өндөр гэж үзсэн.
- Иргэд системийн ажиллах зарчмыг ойлгохгүй байсан нь итгэлцэлд сөргөөр нөлөөлсөн.
- Үр ашиг багатай, зардал өндөр гэж дүгнэсэн.
- Нууцлал, хяналт, шударга байдал хангагдаж байгаа эсэх нь эргэлзээтэй байсан.

Туршлага/ сургамж

Техник технологийн шийдэл сайн байсан ч, иргэдийн итгэлцэл, ил тод байдал, сонгуулийн зарчмыг хангах талаас асуудалтай тулгарсан. Ингэснээр ардчиллын чанар буурч болзошгүй гэж дүгнэсэн. Уг туршилтаар иргэдийн боловсрол, нийгмийн бэлтгэл технологиос дутахгүй чухал гэдэг нь харагдсан.

4. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

4.1. Саналууд

- Цаашид Монгол улсад гадаадад байгаа иргэдээс цахимаар санал авах тогтолцоог бүрдүүлэхийн тулд сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж цахимаар санал авах боломжийг нээх, цахим гарын үсгийн тухай хуульд мөн нэмэлт өөрчлөлт оруулж санал баталгаажуулалтад ашиглах зэрэг хууль, эрхзүйн шинэчлэлийг хийх шаардлагатай. Одоогоор манай улсын сонгуулийн хуульд цахимаар санал авах боломжийг дэмжсэн заалт байхгүй.
- Мөн сонгуулийн санал хураалтын үед кибер халдлагаас сэргийлэх, хянах, таслан зогсоох, хариуцлага хүлээх субъектүүдийг зааж өгөх хэрэгцээ урган гарахаар байна. Бид цахимаар санал авах үйл ажиллагааг зохион байгуулахад кибер халдлагыг хэн таслан зогсоох, хэн дэмжлэг үзүүлэх, хэн хариуцлага хүлээх талаар нарийвчлан зохицуулалт байхгүй байна.
- Манай улсын бусад улсаас ялгарах давуу тал нь сонгуулийн насны иргэдээ танин баталгаажуулах боломжтой танилт, нэвтрэлтийн ДАН систем, төрийн мэдээлэл солилцооны ХУР систем зэрэг хоорондоо холбогдсон дэд бүтэцтэй бөгөөд эдгээр бэлэн дэд бүтэц дээр суурилж цахим сонгуулийн шийдэл боловсруулах бүрэн боломжтой. E-mongolia систем дээр иргэнээс санал авах хэсгийг бий болгож болох боловч үндсэн системтэй хамааралгүй байдлаар зохион байгуулах шаардлагатай. Учир нь цахимаар санал авах хэсэг нь ачаалал өндөр авах, халдлагад өртөх эрсдэлтэй тул үндсэн системд нөлөөлөхгүйгээр салангид байдлаар бүтээх нь зүйтэй юм.
- Ингэхдээ ДАН системийн танилт нэвтрэлтийг шинэ шатанд гаргаж, ДАН-ийн дараагийн хувилбар дээр гадаадад байгаа иргэнийг танин баталгаажуулах олон шатлалт шийдлийг оруулах нь зүйтэй. Энэ дунд гадаадад байгаа иргэдэд тоон гарын үсэг тараах, нүүр царайны танилт, видео хэлбэрээр өөрийгөө

баталгаажуулах зэрэг арга орно. Филиппин улсын хувьд гадаадад байгаа иргэд нь заавал элчин сайдын яам болон консулын газартаа очиж сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлдэг нь иргэнийг заавал ирж очиход хүргэж, чирэгдэл учруулж, санал өгөх иргэдийн тоог багасгах том хүчин зүйл болдог нь харагдаж байна. Тиймээс бид уг процессыг алгасаж ДАН-ийн танилт, нэвтрэлтийг Иргэний бүртгэлийн болон өмнөх сонгуулийн сонгогчийн бүртгэлтэй харьцуулан шалгах замаар иргэддээ хүндрэл учруулахгүй байх, өөрөөр хэлбэл заавал элчин сайдын яам, консулын газарт очиж бүртгүүлдэг байдлыг арилгах тал дээр анхаарах хэрэгтэй.

- Иргэдийн итгэл алдагдвал тухайн санал хураалтыг дахин явуулах боломжгүй болох бөгөөд ДАН, И-Монголиа, ХУР системийг ашиглан шийдэл боловсруулах тохиолдолд эхлэхээс авхуулаад дуусах хүртэлх бүх процесст хөндлөнгийн аудит ажиллуулах зайлшгүй шаардлагатай. Мөн түүнчлэн кибер халдлагаас урьдчилан сэргийлж шинэчлэгдсэн криптограф, e2ee, penetration test, red team зэрэг арга, хэрэгслүүдийг ашиглах, иргэдийн цахим боловсролыг дээшлүүлэх гарын авлага, сургалт, видео хичээл зэргийг хүртээмжтэй түгээх, хөндлөнгийн аудит, ил тод тайлагнал, кодыг нээлттэй болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна.
- Цахим санал хураалтын системийг дан ганц И-Монгол Академи УТҮГ-ийн нөөц бололцоонд тулгуурлахаас илүүтэй зөвлөх үйлчилгээний багуудыг эрх зүй, технологи, аюулгүй байдал зэрэг чиглэлүүдээр сонгон шалгаруулж ажлуулах, үндэсний хэмжээнд эксперт, судлаачдын багийг бүрдүүлэн бүтэн судалгаа хийх, архитектур шийдэл боловсруулах ажилд хүчин зүтгүүлэх нь ирээдүйд учирч болох эрсдэлээс сэргийлэх том алхам болох юм.
- Сонгуулийн цахим системийг бүтээх ажлыг гадаадын компанид хариуцуулах нь иргэд, олон нийтийн зүгээс гуравдагч улсын нөлөөнд автах вий гэсэн болгоомжлол, хардлагыг бий болгох талтай. Тиймээс системийг дотоодын гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх, ингэхдээ нийгэм, олон нийтийг төлөөлөхүйц хөндлөнгийн этгээдийн хяналтыг бий болгох хэрэгтэй гэж үзэж байна.
- Системийн аюулгүй байдлын хувьд бид Филиппин улсаас илүүтэй Европын орнуудын туршлагыг судлах, тэр дундаа Швецарь, Эстони улсуудын туршлагаас хэрэгжүүлэх нь тохиромжтой байна.

4.2. Боломжит халдлагууд (кибер эрсдэлүүд)

№	Халдлагын төрөл	Тайлбар	Үр дагавар
1	DDoS халдлага	Е-Mongolia, санал хураалтын серверүүд рүү зэрэг олон хүсэлт илгээн системийг унагаах	Систем түр хугацаагаар ажиллахгүй, иргэд санал өгч чадахгүй болох
2	Фишинг халдлага	Хуурамч санал хураалтын хуудас илгээж хэрэглэгчийн нууц үг, ID, eSignature авах	Хуурамч санал өгөлт, системд нэвтрэх эрх алдлагдах

3	Хувийн түлхүүр алдагдах (Key compromise)	Цахим гарын үсэг буюу eID-ийн нууцлалын түлхүүр алдагдах	Бусдын өмнөөс санал өгөх, саналын баталгаагүйд хүргэх
4	MITM (Man-in-the-middle)	Иргэний төхөөрөмж, сервер хоёрын хооронд өгөгдөл дамжих үед хакер оролцох	Саналын нууцлалыг алдагдуулах, мэдээлэл өөрчлөх
5	Client-side malware	Иргэний төхөөрөмж халдварлагдсан, саналын интерфэйсийг өөрчлөх	Иргэний сонголтыг өөр нэр дэвшигч рүү өгүүлэх
6	System insider attack	Дотоод ажилтан системд санаатай хохирол учруулах	Санал тооллогод нөлөөлөх, дата устгах

Дээрх төрлийн халдлагууд гарах магадлалтай тул тус бүрт авах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хариуцаж эзэн, багуудыг зохион байгуулж, үүрэгжүүлэх шаардлагатай.



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2025.06.24 № 01/3133


танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.БУМ-ОЧИР ТАНАА

Таны 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-03/7424 дугаартай албан бичигт дурдсан асуудлаар тус яамнаас дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хилийн чанадад оршин суугаа монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол нэгдсэн системийг ашиглан цахимаар сонгуульд оролцох эрхийг хангахыг тус яамнаас дэмжиж байна.

2. Сонгуулийг цахим хэлбэрээр явуулахдаа иргэдийн танин баталгаажуулалт, мэдээлэл дамжуулалт болон сүлжээний аюулгүй байдлыг сайтар хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэх нь зүйтэй.



Б.БАТЦЭЦЭГ

115251602



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Цагдаагийн гудамж, 11 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171
Утас: 32 05 02, Цахим шуудан: contact@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.burtgel.gov.mn

2025.06.19 № 1/8143
танай 2025.06.17 -НЫ № 240-03/9424-Т

Хариу хүргүүлэх тухай

Улсын бүртгэлийн байгууллага сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх, нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тус байгууллага хуулиар заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид орсон шинэлэг зохицуулалтыг хэрэгжүүлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв үйлдэхтэй холбоотойгоор 2024 онд дараах программ хангамжийг шинэчлэн боловсруулж хэрэглээнд нэвтрүүлсэн. Тухайлбал:

1. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах программ хангамж;
2. Сонгогчдын ирц бүртгэлийн мэдээ харуулах программ хангамж;
3. Гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх программ хангамж;
4. Сонгогчийн ирц бүртгэлийн программ хангамж.

Дээрх программ хангамжийг шинэчлэн боловсруулж сонгуулийн үйл ажиллагаанд ашигласнаар сонгогчдын нэрийн жагсаалттай танилцсан сонгогч цахимаар санал хүсэлт гаргах, өөрийн хаягт бүртгэгдсэн нийт сонгогчийг харах, нягтлах, сонгуулийн ирцийг тухай бүр сонгуулийн хэсэг тус бүрээр харах, ирцийн мэдээг шууд дамжуулах, гадаад улсад ажиллаж амьдарч байгаа иргэд сонгуульд оролцохоо цахимаар илэрхийлэх, бүртгэгдсэн эсэхийг цахимаар шалгах зэрэг боломжийг бүрдүүлэн үйл ажиллагааг шуурхай болгон төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулсан ажил болсныг дурдаж байна.

Хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн сонгуулийн санал өгөх боломжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (emongolia)-ийг ашиглан цахимаар сонгуульд оролцох эрхийг ханган ажиллахтай холбоотой дараах саналыг хүргүүлж байна.

1. Тоон гарын үсгийн олголтыг эрчимжүүлэх;
2. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (emongolia)-ийг ашиглан сонгогчийг таньж баталгаажуулахдаа царай таних системийг хэрэглээнд нэвтрүүлэх.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ДАВААНЯМ



ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

34 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүрэг,
Улаанбаатар хот, 18170
Утас: 7018 0092, Цахим шуудан: info@datacenter.gov.mn,
Цахим хуудас: www.datacenter.gov.mn

2025. 06. 20 № 01/215
танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1 -т заагдсан танилт, нэвтрэлтийн "ДАН" системийг "Үндэсний дата төв" УТҮГ, 18.5.6 -т заагдсан төрийн үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia" системийг "И-Монгол Академи" УТҮГ тус тус хариуцан ажилладаг билээ.

Энэхүү танилт, нэвтрэлтийн "ДАН" системийг шинэчлэх ажлын төлөвлөгөөг "Үндэсний дата төв" УТҮГ -ын зүгээс "И-Монгол академи" УТҮГ -тай хамтран боловсруулаад байна. Тухайн шинэчлэлийн хүрээнд танилт, нэвтрэлтийн "ДАН" системийг үндэсний баталгаажуулагч аппликейшн болгон хөгжүүлж дараах ажлууд хийгдэхээр төвлөгдсөн. Үүнд:

- Гадаад улсад ажиллаж амьдарч буй иргэдийг таньж баталгаажуулах, (хиймэл оюуны царай танилт + баталгаажуулалтын шийдэл)
- Гадаад утасны дугаар бүртгэх боломжийг бүрдүүлэх,
- Нотариатын итгэмжлэлээр нэвтрэх, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх,
- УБЕГ -ын клауд тоон гарын үсгийн систем, "Esign" -ийг нэгтгэх,
- Зайнаас хэрэглэгчээ таних модуль "KYC" үйлчилгээний боломжийг бүрдүүлэх,
- Хуулийн этгээдийн нэвтрэлтийг хялбарчлах,
- Нууц үггүй нэвтрэлт /Fido2 password authentication/ бий болгох,
- "Google"/"Microsoft" баталгаажилтын аппликейшнтай холбох,
- Баримт бичгүүдэд тоон гарын үсэг зурах боломжийг бүрдүүлэх,
- Хандах эрхийн удирдлагатай болгох,
- Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системийн иргэний баталгаажилтын гол суваг болгох,

- Төрийн цахим үйлчилгээний түвшин бий болгож, хандалтын удирдлагаар хуваарилах,
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, илүү хялбар бусад нэмэлт боломжуудыг хөгжүүлэх. •

Иймээс клауд тоон гарын үсгийн олголтыг эрчимжүүлж тус системээр баталгаажуулж нэвтрүүлэх замаар хилийн чанад дах Монгол Улсын иргэд ИМонгол төрийн цахим үйлчилгээний системийг ашиглах, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангуулах боломжтой байна.

ЗАХИРАЛ



М.БАТТУЛГА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.БУМ-ОЧИР ТАНАА

**КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

Мэдээлэл, Технологийн Үндэсний Парк 105 тоот,
Бага тойруу 49, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976-51) 26 51 19,
Цахим шуудан: info@cscouncil.gov.mn

2025.06.20 № 65
танай 2025.06.17 -ны № УМД-03/7424-Т

Санал хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн ирүүлсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтэд санал авах тухай албан тооттой танилцлаа. Одоо мөрдөгдөж байгаа Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид хилийн чанад дахь Монгол Иргэдийг цахим сонгуульд оролцуулахтай холбоотой зохицуулалт байхгүй тул зарчмын хувьд дараах нэмэлт, өөрчлөлтийг тусгах саналтай байна. Үүнд:

- Сонгуулийн автоматжуулсан системийг Мэдээллийн аюулгүй байдлын аудит, Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд хамруулж, эмзэг байдал, аюулгүй байдлын зөрчил илрээгүй тохиолдолд уг системийг ашиглан сонгуулийг зохион байгуулах;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан системийг ашиглан хилийн чанад дахь Монгол Улсын иргэнийг таньж баталгаажуулсны үндсэн дээр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэх;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэгт заасан сонгогчийн эрхийг цахим орчинд хангуулах талаар арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Цахим сонгуулийн санал хураалтад Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв хяналт тавих;
- Сонгуулийн санал авах өдөр Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангаж кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Ч.ЗОЛБАЯР

1525040170



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон
Сүхбаатарын талбай 6, Утас: 51-263882, Факс: 329883,
И-мэйл: info@nsc.gov.mn

2025, 06.20 № 5/195
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ
Д.БУМ-ОЧИР ТАНАА


Санал хүргүүлэх тухай

Танаас 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-03/7424 дугаар албан бичгээр ирүүлсэн санал ирүүлэх тухай албан бичигтэй танилцлаа.

Хилийн чанад дахь Монгол иргэд цахимаар сонгуульд оролцоход дараах асуудлыг анхаарч, шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Хилийн чанад дахь Монгол иргэд саналаа өгсөн эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа буюу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/25 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журам”-ын 2.14-т заасны дагуу гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн санал авах өдөр санал өгсөн сонгогчоор гарын үсэг зуруулж буй үйл ажиллагааг цахим хэлбэрт эрсдэлгүй шилжүүлэх;
2. Хилийн чанадаас санал өгч буй тухайн иргэн өөрийн өгсөн саналаа системд хэрхэн бүртгэгдэж байгааг хянах боломж, нөхцөлөөр хангах;
3. Хилийн чанадаас санал өгч буй иргэний санал өгөх төхөөрөмж (гар утас, таблет, компьютер), санал дамжуулах сүлжээ, дүн хүлээн авах, нэгтгэх системийн кибер аюулгүй байдлыг бүрэн хангах;
4. Цахим үйлчилгээний системд аливаа кибер халдлага, зөрчил үүссэн үед хариу арга хэмжээ авах хүний нөөц, чадамжийг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр хилийн чанад дахь Монгол иргэдийг цахимаар сонгуульд оролцуулах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



А.БЯМБАЖАРГАЛ

00400346



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 14 33,
Цахим шуудан: international@nso.mn,
Цахим хуудас: www.nso.mn

2025.06.30 № 01/565
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН ДУЛАМЫН БУМ-ОЧИР
ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн төрийн цахим үйлчилгээний “И-Монгол” системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах асуудлаар ажлын хэсгээс гаргах зөвлөмж, дүгнэлтийн төсөлд манай байгууллагаас дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хил хамгаалах ерөнхий газар болон Гадаад харилцааны яамны мэдээлэлд тулгуурлаж гадаад улсад оршин суугаа иргэдийн мэдээллийн санг үүсгэх.
2. Үндэсний статистикийн хорооноос уг мэдээллийн санг бүрдүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Б.БАТДАВАА



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИСС**

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

2025.06.30 № 01/1183

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн санал ирүүлэх тухай 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-03/7424 дүгээр албан бичигтэй танилцлаа.

Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлах ажлын хэсгээс гарах дүгнэлтэд тусгах саналыг хавсарган хүргүүлэв.


Хавсралт ... хуудастай.

ДАРГА



Д.СҮНЖИД

150021894



1. Сонгуулийн тогтолцоо, сонгуулийн түвшнээс үл хамааран гадаад улсад байгаа иргэдийн санал өгөх эрхийг хангасан зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах;

Үндэслэл, шаардлага: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй” гэж заасан, мөн хуулийн 66¹ дүгээр зүйлийн 66^{1.6} дахь хэсэгт “Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө”, 59 дүгээр зүйлийн 59.4.2-т “энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх”, 44 дүгээр зүйлийн 4.3.2-т “Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэж заасан нь гадаадад байгаа сонгогчид зөвхөн нам, эвслийн жагсаалтад саналаа өгөх бөгөөд тойрогт нэр дэвшигчдэд санал өгөх эрхгүй байна.

Монгол Улстай ижил төстэй, сонгуулийн холимог тогтолцоо хэрэглэж байгаа бусад улс орны туршлагаас харахад гадаадад байгаа сонгогчдыг сонгуулийн холимог тогтолцооны 2 бүрэлдэхүүний аль алинд нь санал өгөх боломжоор хангаж, сонгуульд оролцуулах явдал нийтлэг байна.¹ Энэ тохиолдолд сонгогчийг аль нэг мажоритар тойрогт хуваарилах шаардлага үүсэх бөгөөд Итали Улс хувь тэнцүүлэх тогтолцооны зарчмын дагуу намын жагсаалтаар санал хураах сонгуулийн 4 тойргийг гадаадад байгуулдаг, Герман, Япон², Шинэ Зеланд зэрэг улсад тухайн сонгогчийг эх орондоо байх үеийн хамгийн сүүлд бүртгэгдсэн тойргийнх нь саналын хуудсаар санал өгүүлэх, эсвэл тухайн улсын парламентын ордон байрладаг тойрогт санал өгүүлдэг зэрэг жишээ байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар гадаад улсад байгаа сонгогчийн санал өгөх эрхийг олгох зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

2. Гадаад улсад байгаа бүх иргэдийг саналаа өгөх боломжоор хангах;

Үндэслэл, шаардлага: Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ээс 216 улс орныг хамруулан хийсэн судалгаагаар 150 улс буюу 69.4 хувь нь гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авдаг бол 66 улс буюу 29.6 хувь нь авдаггүй байна. Эдгээр улс орнуудын 109 нь буюу 50.5 хувь нь санал авах

¹ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Сонгуулийн холимог тогтолцоо: Онол, практик, ННФ, 2024 он, 9 дэх тал

² Тус улсад гадаадад байгаа сонгогчид зөвхөн намын жагсаалтаар санал хураахад оролцож байсан бөгөөд мажоритар суудлын төлөө өрсөлдөж буй нэр дэвшигчид санал өгөх саналын хуудсыг өгөхгүй байгааг Дээд шүүх нь хууль бус гэж 2005 онд шийдвэрлэсэн байна.

байранд, 53 буюу 24.5 хувь нь шуудангаар, 15 буюу 7 хувь нь цахимаар, 19 буюу 8.8 хувь нь итгэмжлэгдсэн хүнээр дамжуулж санал авдаг.³

Үндэсний статистикийн хорооны 2020 оны тооллогын дүнгээр Монгол Улсын 122,301 иргэн гадаад улсад амьдарч байснаас 100,000 орчим нь 20-иос дээш насныхан эзэлж, энэ нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн Дорнод, Хэнтий аймгийн сонгогчдын тоотой дүйцэхүйц байна.

2012-2021 онд явагдсан дөрвөн сонгуульд 7,394 сонгогч буюу 7.4 хувь нь сонгуульд оролцохоор бүртгүүлж, 5,618 буюу 5.6 хувь нь сонгуульд оролцож саналаа өгч байсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 33 улс дахь Дипломат төлөөлөгчийн 47 газраар дамжуулан гадаад улсад ажиллаж, амьдарч, суралцаж байгаа иргэнээс 13,095 сонгогч санал өгөхөөр бүртгүүлснээс 74.6 хувь буюу гадаадад байгаа нийт иргэдийн 9,768 сонгогч Дипломат төлөөлөгчийн газарт очиж саналаа өгсөн байна.⁴ 2024 онд санал өгсөн сонгогчид нь гадаадад тоологдсон нийт хүн амын⁵ дөнгөж 10 орчим хувь буюу 10 сонгогч тутмын 1 нь байгаагаас харахад цаашид санал хураалтын шинэ арга хэлбэрийг сонгогчдод санал болгох хэрэгтэйг харуулж байна.⁶

Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа иргэд зөвхөн тухайн газарт буюу салбар комиссын тогтоосон санал авах байранд биечлэн очиж саналаа өгөхөөр зохицуулсан нь тухайн Дипломат төлөөлөгчийн газар байрладаг хотоос өөр хот, тосгонд амьдарч байгаа иргэдэд эдийн засгийн болоод цаг хугацааны хувьд хүндрэл учруулж байсан тухай ажиглалт хийсэн төрийн бус байгууллагуудын тайланд дурджээ.

Иймд Дипломат төлөөлөгчийн газар байрладаг хотод биечлэн ирж саналаа өгөх бус техник технологийн дэвшлийг ашиглаж гадаад улсад байгаа иргэдийн сонгох эрхийг бүрэн хангахад чиглэсэн цахим, шуудан, харилцаа холбооны сүлжээг ашиглах зэргээр хувилбарт байдлаар саналаа өгөх боломжийг олгох, тойрогт нэр дэвшигчид санал өгөх нээлттэй зохицуулалтыг судлан зохицуулах шаардлагатай байна.

Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлд тусгасан “Сонгох, сонгогдох эрх: 2024 оны сонгуулийн үйл ажиллагаа” бүлгийн хүрээнд гадаад улсад байгаа иргэдийн сонгох эрхийн асуудлыг хөндсөн бөгөөд тус илтгэлээс холбогдох мэдээллийг дэлгэрүүлж харах боломжтой.

-оОо-

³ <https://www.idea.int/data-tools/data/voting-abroad>

⁴ Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв комиссын мэдээлэл, 2024.06.24, “Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаа дууслаа”, <https://m-election.mn/news/6721>

⁵ Гадаадад оршин суугаа иргэдийн тоог Монгол Улсын хүн ам, орон сууцны ээлжит тооллогын дүнд үндэслэн гаргадаг бөгөөд 2020 оны тооллогоор Монгол Улсын харьяат 3,296,866 хүн тоологдсоны 122,301 нь гадаадад тоологдсон бөгөөд 100,000 орчим нь сонгуулийн насны иргэн байна.

⁶ СЕХ, Ардчилсан сонгууль: Одоо ба ирээдүй, олон улсын онол, практикийн бага хурлын эмхэтгэл, 2022. УБ. 33 дахь тал



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 09 75, Цахим шуудан: gesm@ges.gov.mn,
Цахим хуудас: www.ges.gov.mn

2025.06.20 № 1/289
танай 2025.06.17-ны № 742-03/7424Т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ
Д.БУМ-ОЧИР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Танд дараах саналыг хүргүүлж байна.

1. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд бэлтгэхэд сонгуулийн эрх бүхий иргэдийн суурь бүртгэл, тоон мэдээлэл нь төлөвлөлтийн гол үзүүлэлт болдог. Гэтэл гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааны бэлтгэл хангах, төлөвлөлт хийхэд Монгол улсаас гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа сонгуулийн эрх бүхий нийт иргэдийн талаар эрх бүхий байгууллагуудаас зөрүүтэй тоон мэдээлэл гардаг нь үндсэн хүндрэлийг учруулдаг. Иймд Хил хамгаалах ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Үндэсний статистикийн газрын дээрх чиглэлээр мэдээлэл бүрдүүлэх, солилцох үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлох, дундын мэдээллийн нэгдсэн платформ хөгжүүлэх,

2. Дээр дурдсанаар гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн нэгдсэн, тодорхой тоон мэдээлэлгүйгээс шалтгаалан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхийн тулд гадаад улсад байгаа иргэд сонгуульд оролцохоо зайлшгүй урьдчилан илэрхийлж, бүртгүүлэх шаардлагатай болдог. Иймд дээр дурдсанаар дундын мэдээллийн нэгдсэн платформ хөгжүүлж, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хэрэглэх боломж бүрдүүлбэл гадаад улсад байгаа иргэд саналаа өгөхөд тавигддаг урьдчилсан бүртгэлгүй болох, хүндрэлийг арилгах боломж бүрдэх юм. Хэрэв дундын мэдээллийн нэгдсэн платформ хөгжүүлэх боломжгүй тохиолдолд урьдчилсан бүртгэлийн хугацааг багадаа 30-аас доошгүй хоногийн хугацаанд, цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид оруулах.

3. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад зөвхөн цахимаар санал өгөх хувилбараас гадна шуудангаар санал өгөх, дипломат төлөөлөгчийн газар байхгүй боловч иргэд олон тоогоор ажиллаж, амьдардаг хотуудад санал авах ажиллагааг зохион байгуулах зорилгоор салбар

1525040388

комисс байгуулах, салбар комиссын санал авах байруудад сонгуулийн автоматжуулсан систем, санал тоолох төхөөрөмжөөр сонгогч саналаа өгөх зэргээр санал өгөх хувилбар, боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох сонгуулийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах,

4.Цахим санал хураалтыг санал авах үйл ажиллагаанд нэвтрүүлэх тохиолдолд сонгогчийн бүртгэл, танилт, баталгаажуулалтад царай таних технологийг нэвтрүүлэх, сонгогчийн саналын нууцлалын баталгаат байдлыг хангах цахим шийдлийн аюулгүй байдал, олон улсын хөндлөнгийн аудитаар баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль болон холбогдох сонгуулийн хууль тогтоомжид заасан үндсэн чиг үүргийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэх, сонгуулийг ардчилсан зарчмын дагуу зохион байгуулах, хөгжүүлэхэд чиглэсэн бүх талын санал, санаачлага, сайн туршлага бүрийг идэвхтэй дэмжин, дээрх саналтай холбоотой нарийвчилсан судалгаа, мэдээллийг бэлтгэхэд хамтран ажиллахаа илэрхийлж байна.

Хавсралтаар Филиппин улсад зохион байгуулагдсан сонгуулийг ажигласан талаарх мэдээлэл 3 хуудас, иргэнийг таних, бүртгэх үйл ажиллагаанд царай таних технологи ашиглах танилцуулга 14 хуудас, Монгол Улсад цахим санал хураалт нэвтрүүлэх боломжийн талаарх судалгаа 20 хуудас, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд зарцуулсан төсвийн харьцуулалт 1 хуудас нийт 37 хуудас баримтыг тус тус хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Цагдаагийн гудамж, 11 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171
Утас: 32 05 02, Цахим шуудан: contact@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.burtgel.gov.mn

2026.02.02 № 1/1212

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын УИХ-ын гишүүн Д.Бум-Очир ахлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, сонгогчийн санал авах хувилбарыг нэмэгдүүлэх зорилгоор “урьдчилсан санал хураалт явуулах”-тай холбоотой дараах саналтай байна. Үүнд:

1. Урьдчилсан санал авах үйл ажиллагааг сонгуулийн санал авах өдрөөс 21 хоногийн өмнө зохион байгуулж, санал авах ажиллагааг хуанлийн 5 хүртэл хоногоор үргэлжлүүлэн санал авах сүүлийн 2 өдрийг Бямба, Ням гаригт байхаар зохион байгуулах;

2. Мөн энэ хугацааг хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа сонгуулийн эрх бүхий иргэний сонгуулийн санал авах хугацаатай адил байхаар тооцох;

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6.3 дахь хэсгийн “хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 60 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг” гэснийг, 24 дүгээр зүйл “Сонгогч шилжих” гэснийг тус тус хасаж, 20 дугаар зүйл “Гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах” гэснийг дахин найруулах саналтай байна.

Түүнчлэн урьдчилсан санал авах үйл ажиллагаатай холбоотой 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ын байр, төвлөрсөн сум, суурин газарт байрлуулж сонгогчийг бүртгэх, сонгуулийн санал авах тусгай зориулалтын тоног төхөөрөмж 200 ширхэг шинээр худалдан авахын зэрэгцээ сонгогчийн ирц бүртгэлийн программ хангамж, ирцийн мэдээ харуулах программ хангамж зэргийг шинэчлэн боловсруулах үүнтэй холбоотойгоор улсын бүртгэлийн байгууллагын болон хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын холбогдох албан хаагчдыг сурган дадлагажуулах шаардлагатай байна.

Жич: Сонгуулийн санал авах өдрийн өмнө хийгдэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт...хуудастай.

ДАРГА




Д.ДАВААНЯМ

142602671

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2026 оны 1/ дугаар албан бичгийн хавсралт





УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГААС СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ
ӨДРӨӨС ӨМНӨ ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ

1. Урьдчилан санал өгсөн сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгаж төлөв оноох. Ингэхдээ хилийн чанадад цагийн зөрөөнөөс шалтгаална. (2 өдөр)
2. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхтэй холбоотой МУЕСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.9.1-19.9.5, 23 дугаар зүйлд заасан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийг сонгогчдын нэрийн жагсаалтад тусгаж төлөв оноох. Жич: сонгуулийн хэсгийн хороонд үүссэн лавлагааны мэдээлэлтэй тулган шалгана. (1 өдөр)
3. Урьдчилан санал өгсөн сонгогчийн болон хуулийн дагуу үүссэн лавлагааг хэвлэх, сонгогчдын нэрийн жагсаалттай тулгах (1 өдөр)
4. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтныг сургаж дадлагажуулах (1 өдөр)
5. Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтэст үүссэн лавлагааг сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжид итгэмжлэгдсэн ажилтны оролцоотой тусгах. (1 өдөр)
6. Сонгогчдын нэрийн жагсаалтын сүүлийн хувилбарыг бэлтгэн нягтлан шалгаж, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх. (1 өдөр)
7. Сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогчийн бүртгэлийн тоног төхөөрөмжийг сонгуулийн хэсгийн хороодод хүргэх. Аймаг, сумын төвөөс алслагдсан хэсгийн хороодод хүргэхэд хугацаа шаардагдана. (1-2 өдөр)
8. Хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн хүсэлтээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээлгэн өгөх. (санал авахаас 3 хоногийн өмнө)
9. Сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийн иж бүрдлийн хэвийн ажиллагааг шалгаж, улс орон даяар туршилт хийх. (сонгуулийн санал авах өдрийн өмнө)

---oOo---

